МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.БАЯРМАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
Сүхбаатар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 07, Факс: (976-51) 26 24 08
Цахим шуудан: info@sabbar.gov.mn,
Цахим хуудас: www.sabbar.gov.mn

2026.10.07 № ХЭГ/3409
танай 2026.09.03 -ны № 53 -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 33 хуудастай.

Хүндэтгэсэн,

Монгол Улсын Засгийн газар
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Баттөмөр Энхбаяр
2026.10.08 11:47

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГЫН ХАРИУ

### Нэг.Мөчлөг сөрсөн, алдагдалгүй төсвийн бодлогын хэрэгжилтийн талаар

*2024 онд эдийн засгийн таатай үед төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийн алдагдал болон өрийг бууруулах, хуримтлалыг нэмэгдүүлэх замаар мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлэх, 2025-2027 оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байлгах бодлого чиглэлийг баримталсан. Үүнтэй холбогдуулан:*

**1.1.Дээрх бодлогын зарчим өнөөдөр хүчин төгөлдөр хэвээр байгаа эсэх талаарх Засгийн газрын байр суурь**

Өмнөх жилүүдэд эдийн засгийн өндөр өсөлт, орлогын таатай нөхцөлийг ашиглан төсвийн алдагдлыг бууруулах, хуримтлал бий болгох замаар мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлэхийг зорьж ирсэн. Энэхүү бодлогын суурь зарчим болох төсвийн сахилга бат, өрийн тогтвортой байдлыг хангах, орлогоос давсан зарлагын өсөлтийг хязгаарлах Засгийн газрын бодлого хэвээр хадгалагдаж байна.

2026 оны тухайд эхний хагас жилийн гүйцэтгэлээр эдийн засгийн дотоод идэвхжил суларч, өрхийн бодит орлого 4.8 хувиар буурсан, мөн олон улсад тодорхой бус байдал өндөр байгаагийн нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил сулрах эрсдэлтэй байна. Иймд эдийн засгийн идэвхжил саарсан үед мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх замаар эдийн засгийн эрэлтийг дэмжих, дунд хугацаанд төсвийн алдагдлыг бууруулах бодлогыг баримталж байна.

Өөрөөр хэлбэл, 2026 оны төсвийн орлогын гүйцэтгэл, эдийн засгийн нөхцөл байдал болон нийгэм, эдийн засгийн зайлшгүй хэрэгцээг харгалзан төсвийн бодлогын богино хугацааны зорилтыг уян хатан тодорхойлж, 2026 оны төсвийн тодотгол болон 2027 оны төсвийн хүрээнд төсвийн сахилга батыг сайжруулах, зарлагыг эрэмбэлэн санхүүжүүлэх, алдагдлыг хязгаарлах бодлого баримталж байна. Түүнчлэн, дунд хугацаанд мөчлөг сөрсөн төсвийн бодлогын зарчим хэвээр хадгалагдаж, эдийн засгийн өсөлт өндөр байх үед төсвийн алдагдлыг үе шаттай бууруулах, төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах замаар төсвийн бодлогын тогтвортой байдлыг хангана.

**1.2.Экспортын орлого болон гадаад худалдааны ашиг нэмэгдэж, гадаад секторын нөхцөл харьцангуй таатай байгаа үед төсвийн зарлага, алдагдлыг нэмэгдүүлж байгаа нь мөчлөг сөрсөн төсвийн бодлогын зарчимтай нийцэж байгаа эсэх талаарх макро эдийн засгийн тооцоо, судалгаа, дүгнэлт**

Экспортын орлого, гадаад худалдааны ашиг нэмэгдэж байгаа нь эдийн засгийн гадаад орчны хувьд эерэг үзүүлэлт хэдий ч төсвийн бодлогын мөчлөгийн шинжийг зөвхөн эдгээр үзүүлэлтээр тодорхойлох нь учир дутагдалтай. Учир нь эдийн засгийн өсөлтийн эх үүсвэр, дотоод эрэлтийн нөхцөл, уул уурхайн бус салбарын идэвхжил зэрэг хүчин зүйлсийг хамтад нь авч үзэх шаардлагатай.

2026 оны эхний 8 сарын байдлаар экспортын орлого 14.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 57.2 хувиар өссөн бөгөөд экспортын өсөлтийн 95.7 хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байна. Үүний нөлөөгөөр гадаад худалдааны тэнцэл

6.0 тэрбум ам.долларын ашигтай, төлбөрийн тэнцэл эхний 7 сарын байдлаар 826.0 сая ам.долларын ашигтай гарсан нь гадаад секторын нөхцөл байдал харьцангуй таатай байгааг илтгэж байна.

Гэсэн хэдий ч гадаад секторын эерэг үзүүлэлт нь эдийн засгийн дотоод суурь нөхцөл сайжирсныг дангаараа илэрхийлэхгүй. Тухайлбал, 2026 оны II улиралд эдийн засгийн өсөлт 7.7 хувьд хүрсэн боловч уг өсөлтийн 3.9 нэгж хувийг уул уурхайн салбар дангаараа бүрдүүлсэн. Харин аж үйлдвэр, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга, цахилгаан, ус хангамж зэрэг уул уурхайн бус салбаруудын өсөлтийн оролцоо өмнөх оны мөн үеэс буурсан байна. Мөн уул уурхайн бус салбарын гарцын зөрүү сөрөг түвшинд байгаа нь эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчин чадал бүрэн ашиглагдахгүй байгааг харуулж байна. Түүнчлэн, эрэлтийн буюу эцсийн ашиглалт талаас эдийн засаг 2026 оны эхний хагас жилд 7.8 хувиар өссөний 13 нэгж хувийг гадаад эрэлт бүрдүүлсэн бол дотоод эрэлт 5.2 нэгж хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг хязгаарласан байна.

Үүний зэрэгцээ манай улсын дотоод эрэлт мөн харьцангуй сул байна. Тухайлбал, өрхийн хэрэглээний өсөлт 2026 оны II улирлын байдлаар 0.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 нэгж хувиар буурсан бол өрхийн бодит орлого 2.8 сая төгрөгт хүрч, 4.8 хувиар буурсан байна. Мөн сүүлийн саруудад инфляц нэмэгдэж байгаа нь өрхийн бодит худалдан авах чадварт нэмэлт дарамт үзүүлж байна.

Уг нөхцөлд гадаад салбарын таатай нөхцөл байдал нь төсвийн бодлогыг заавал хумих үндэслэл болохгүй. Харин төсвийн бодлогыг уул уурхайн салбарын өсөлтөөс гадуурх эдийн засгийн идэвхжил, дотоод эрэлт, өрхийн бодит орлого сул байгаа хэсэгт чиглүүлэх шаардлага үүсэж байна. Энэ утгаараа төсвийн зарлага болон алдагдлыг нэмэгдүүлж байгаа эсэхээс илүүтэйгээр төсвийн бодлогыг нийгэм, эдийн засгийн аль салбарт чиглүүлж, эдийн засгийн ямар нөхцөлд хэрэгжүүлж байгаа нь төсвийн бодлогын мөчлөг сөрсөн шинжийг тодорхойлно.

Тиймээс 2026 оны хувьд уул уурхайн салбарын өсөлт, экспортын орлогын нэмэгдлийг эдийн засгийн нийт эрэлт хүчтэй байна гэж шууд дүгнэхээс илүүтэй, эдийн засгийн өсөлтийн бүтцийн ялгаатай байдал, уул уурхайн бус салбарын сул идэвхжил, өрхийн бодит орлогын бууралт, дотоод эрэлтийн сааралтыг харгалзан үзэх нь зүйтэй. Энэ нөхцөлд эдийн засгийн сул хэсэгт чиглэсэн төсвийн дэмжлэг нь мөчлөг сөрсөн төсвийн бодлогын зарчимтай нийцнэ гэж үзэж байна.

**1.4.Экспортын гол бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ буурах, гадаад орчин муудах үед эдийн засгийг дэмжих төсвийн бодлогын орон зайг бүрдүүлэх дунд хугацааны төлөвлөлт**

Нэгдүгээрт, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, экспортын биет хэмжээний бууралт нь төсвийн орлого болон гадаад валютын орох урсгалд шууд нөлөөлөх эрсдэлтэй тул уул уурхайн салбарын төсөвт төвлөрүүлэх орлогыг тооцохдоо зах зээлийн үнэ болон тэнцвэржүүлсэн үнийг ашиглан тооцоолдог.

Засгийн газраас төсвийн орлогын төсөөллийг хийхдээ нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа нүүрс болон зэсийн баяжмалын үнийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан аргачлалын дагуу түүхий эдийн үнийн гадаад шок, огцом савлагааг бууруулах үүднээс тэнцвэржүүлсэн үнийг ашиглан тооцдог.

2027 оны төсвийн төсөлд зэсийн зах зээлийн үнийг 12,700 ам.долларoор, тэнцвэржүүлсэн үнийг 10,249.9 ам.доллар байхаар тооцсон бөгөөд төсвийн орлогоо тэнцвэржүүлсэн үнээр тооцон, тэнцвэржүүлсэн үнээс давсан хэсгийн орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах буюу 2027 онд тус санд 483.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон. Харин зах зээлийн үнэ буурсан үед төсвийн орлогод үзүүлэх нөлөөллийг сааруулах зорилгоор тус сангаас зарцуулах зохицуулалттай. Ингэснээр төсвийн бодлогын уул уурхайн үнийн мөчлөгөөс хамаарах хамаарлыг бууруулж, гадаад орчноос үүсэх эрсдэлийг сааруулан, дунд хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хангана.

Хоёрдугаарт, ирэх онд эдийн засгийн дотоод идэвхжил сулрах эрсдэлтэй байгаа тул дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд төсвийн алдагдлыг 2027 онд дотоодын нийт бүтээгдэхүүний -2.0 хувь, 2028 онд -1.5 хувь, 2029 онд -1.0 хувь байхаар төлөвлөсөн. Энэ нь төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлэх замаар нийт эрэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Ингэснээр эдийн засгийн өсөлт саарах эрсдэлээс тодорхой хэмжээнд сэргийлнэ. Нөгөөтээгүүр төсвийн алдагдлыг дунд хугацаанд үе шаттай бууруулахаар төлөвлөж байгаа нь төсвийн бодлогын орон зайг бий болгож байна.

**1.5.2024 оны 12 дугаар сараас хойш 2027 оны төсвийн тэнцлийн зорилтод оруулсан өөрчлөлт бүрээр тэнцвэржүүлсэн орлого, урсгал болон хөрөнгийн зардал, суурь тэнцэл, төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн үзүүлэлтийн харьцуулалт**

/тэрбум төг/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2025 БАТ | 2025 ТОД | 2026 БАТ | 2026 ТОД | 2027 ТӨС |
|---|---|---|---|---|---|
| **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **33,469.9** | **30,209.9** | **31,930.0** | **31,930.0** | **41,280.0** |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **33,431.5** | **31,573.9** | **32,980.0** | **33,978.0** | **43,586.0** |
| Урсгал зарлага | 25,304.6 | 23,964.0 | 24,901.9 | 26,054.0 | 33,583.2 |
| Хөрөнгийн зардал | 8,340.3 | 7,881.6 | 8,568.5 | 8,414.4 | 10,333.3 |
| **НЭГДСЭН ТӨСВИЙН СУУРЬ ТЭНЦЭЛ** | **3,211.8** | **1,809.4** | **2,070.9** | **-** | **-** |
| Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 3.4% | 2.0% | 2.0% | - | - |
| **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ** | **38.4** | **(1,364.0)** | **(1,050.0)** | **(2,048.0)** | **(2,306.0)** |
| Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 0.0% | -1.5% | -1.0% | -2.0% | -2.0% |
| **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **(38.4)** | **1,364.0** | **1,050.0** | **2,048.0** | **2,306.0** |
| Засгийн газрын үнэт цаас | 1716.2 | 1706.1 | 1484.6 | 1811.5 | 2128.5 |
| Засгийн газрын зээл | 87.5 | 65.5 | -411.7 | 779.2 | 32.8 |

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ 2024 онд 41.8 хувь, 2025 онд 39.4 хувьтай тэнцэж байна.

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөлд Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг тусгасны дагуу Засгийн газраас 2026 онд дотоод үнэт цаасны гаргалтыг 1.0 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх, 1.0 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний өрийн баталгаа гаргах, гадаад төслийн зээлийн хүрээнд 3.1 их наяд төгрөгийг авч ашиглах, үүнээс газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөлд 1.8 их наяд төгрөг, Азийн хөгжлийн банкны Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Төсөв, санхүү, эдийн засгийг бэхжүүлэх төсвийн дэмжлэгийн зээлийн хөтөлбөрийн 200 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн эх үүсвэр, Болзошгүй гамшгийн үеийн санхүүжилт болон сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн 125.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн эх үүсвэр буюу нийт 1.2 их наяд төгрөгийг авч ашиглах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 44.5 хувьтай тэнцэх төсөөлөлтэй байна.

Түүнчлэн, 2027 онд Засгийн газраас 2.0 их наяд төгрөгийн дотоод үнэт цаас гаргах, 1.6 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний өрийн баталгаа гаргах, гадаад төслийн зээлийн хүрээнд 3.9 их наяд төгрөгийг авч ашиглах, үүнээс газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөлд 2.5 их наяд төгрөг, Азийн хөгжлийн банкны Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд боломжит үлдэх Болзошгүй гамшгийн үеийн санхүүжилт болон сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн 125.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн эх үүсвэр буюу 488.8 тэрбум төгрөгийг авч ашиглах арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 49.6 хувьтай тэнцэх төсөөлөлтэй байна.

**Хоёр.2027 оны төсвийн орлого, зарлага, алдагдлын өөрчлөлтийн талаар**

*2026 оны 5 дугаар сард батлсан төсвийн хүрээтэй харьцуулахад 2026 оны 8 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн өөрчлөлтийн төслөөр 2027 оны тэнцвэржүүлсэн орлого ойролцоогоор 6.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж байгаа боловч нийт зарлагын дээд хэмжээ 7.1 их наяд орчим төгрөгөөр өсөж, төсвийн алдагдал 1.713 их наяд төгрөгөөс 2.306 их наяд төгрөг болж нэмэгдэхээр байна. Үүнтэй холбогдуулан:*

**2.1.Орлогын нэмэгдлийн эх үүсвэр тус бүр, мөнгөн дүн, нэг удаагийн болон жил бүр давтагдах шинж**

2027 оны төсвийн төсөлд төрийн өмчит компаниудаас нийт 3.5 их наяд төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцсон. Үүнээс 2.5 их наяд төгрөгийг өмнөх жилүүдэд үүссэн ногдол ашгийн өглөгийг барагдуулах замаар, үлдэх 1.0 их наяд төгрөгийг 2026 оны цэвэр ашгаас хуваарилах ногдол ашгийн орлогоор бүрдүүлэхээр төлөвлөсөн. Цаашид төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдээс төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх, уг орлогын тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр эрх зүй, засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэхээр байна.

Тухайлбал, 2027 оноос дагаж мөрдөж эхлэх Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуульд арилжааны зорилго бүхий компани хуваарилж

болох цэвэр ашгийнхаа 30-аас доошгүй хувийг ногдол ашигт хуваарилах зарчмыг хуульчилсан. Мөн 2026 оны төсвийн тодотголын төслийг дагалдуулан өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын ногдол ашгаас Үндэсний баялгийн санд хуульд заасан хэмжээгээр хуваарилсны дараах үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхээр тусгасан. Ингэснээр уул уурхайн төрийн өмчит компаниудын ногдол ашгийн тодорхой хэсгийг улсын төсвийн орлогын эх үүсвэр болгон ашиглах боломж нэмэгдэнэ.

Үүний зэрэгцээ төрийн өмчит компаниудын засаглал, санхүүгийн үр ашгийг сайжруулах, удирдлага болон хөрөнгийн менежментийг олон улсын сайн туршлагад нийцүүлэх чиглэлээр Франклин Темплтон болон БлэкРок компанитай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, холбогдох ажлыг эхлүүлээд байна. Эдгээр эрх зүй, засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлснээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн ашигт ажиллагаа, ногдол ашиг хуваарилалтын сахилга батыг сайжруулж, улсын төсөвт төвлөрөх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх, цаашид тогтвортой эх үүсвэр болгон бүрдүүлэх нөхцөл бүрдэх юм.

**2.2.Нийт зарлагын өсөлтийн эдийн засгийн ангилал, гол хөтөлбөр, арга хэмжээний задаргаа**

Төсвийн нийт зарлага 2027 онд 43,586.0 тэрбум төгрөгт хүрэхээр байгаа нь өмнөх оноос 10,606.0 тэрбум төгрөгөөр өсөж байна. Үүнээс урсгал зардал 33,583.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 8,681.3 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 10,333.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,764.8 тэрбум төгрөгөөр тус тус өсөхөөр байна. Төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллаар авч үзэхэд цалин хөлсний зардал 9,190.3 тэрбум төгрөгт хүрч 2,199.7 тэрбум төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардал 3,719.8 тэрбум төгрөгт хүрч 771.4 тэрбум төгрөгөөр, татаас ба урсгал шилжүүлгийн зардал 19,100.4 тэрбум төгрөгт хүрч 5,436.7 тэрбум төгрөгөөр тус тус өсөхөөр байна.

**2.3.Нэмэгдсэн зарлагын нэг удаагийн хөрөнгө оруулалт болон жил бүр давтагдах урсгал зардлын харьцаа**

Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсөвт нэмэгдэж байгаа зарлагын хувьд Нийгмийн болон суурь дэд бүтцийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай хуулийн төслийн хүрээнд нэг удаагийн шинжтэй зардал 3.0 их наяд төгрөг, харин байнгын шинжтэй урсгал зардал 4.1 орчим их наяд төгрөг байна.

**2.4.Цалин, тэтгэвэр, тэтгэмж, татаас, шилжүүлэг, бараа үйлчилгээний болон бусад урсгал зардлын өсөлтийн хэмжээ**

Урсгал зардал анх батлагдсан 2026 төсвөөс 8.7 их наяд төгрөгөөр, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тодотголын төслөөс 7.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж байна.

**2.5.Орлого нэмэгдсэн хэмжээгээр төсвийн алдагдал, Засгийн газрын өрийг бууруулах, төсвийн хуримтлалыг нэмэгдүүлэх хувилбарын тооцоо болон харьцуулсан үр дүн**

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 6.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж байгаа боловч тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2,306.0 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа тул Засгийн газрын өрийн хэмжээ буурах нөхцөл үүсэхээргүй байна.

**2.6.Орлогын өсөлтийн экспорт, уул уурхайн салбарын мөчлөгөөс шууд болон шууд бусаар хамаарах хэсгийн хэмжээ**

Уул уурхайн салбараас шууд төвлөрүүлсэн татварын орлого 2024 онд 10,586.1 тэрбум төгрөг буюу нэгдсэн төсвийн орлогын 34 хувь, 2025 онд 9,378.3 тэрбум төгрөг буюу 28 хувь байсан бол 2026 онд 10,033.0 тэрбум төгрөг буюу 28 хувь, 2027 онд 10,908.3 тэрбум төгрөг буюу 24 хувь байхаар тооцсон. Иймд уул уурхайн салбарын үйлдвэрлэл, экспорт, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс шууд хамаарах төсвийн орлого нийт орлогын 24–34 хувийг эзэлж байна.

Үүнээс гадна уул уурхайн салбарт бараа, үйлчилгээ нийлүүлдэг бусад аж ахуйн нэгжийн татварын орлогын тодорхой хэсэг уул уурхайн үйл ажиллагаанаас шууд бусаар хамаардаг. Гэвч одоогийн татвар, гаалийн мэдээллээр уул уурхайн салбарын дам нөлөөллийг тооцох боломжгүй тул дээрх 24–34 хувьд зөвхөн уул уурхайн компаниудын шууд төлсөн татварын орлогыг хамруулсан болно.

**2.7.Экспортын болон уул уурхайн орлого буурах нөхцөлд 2027-2029 оны төсөвт үүсэх эрсдэлийн үнэлгээ**

2027 онд дэлхийн эдийн засгийн өсөлт саарах, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ган, зэсийн эрэлт сулрах болон түүхий эдийн нийлүүлэлт нэмэгдэх зэрэг гадаад орчны эрсдэлээс шалтгаалан нүүрс, зэсийн үнэ болон нүүрсний экспортын биет хэмжээ буурах нь төсвийн орлогод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Мэдрэмжийн шинжилгээгээр нүүрсний үнийн бууралт төсвийн орлогод хамгийн өндөр нөлөөтэй бөгөөд нүүрсний хил үнэ 10 хувиар буурахад төсвийн орлого 560 тэрбум төгрөгөөр, нүүрсний экспортын биет хэмжээ 5 сая тонноор буурахад 260 тэрбум төгрөгөөр, зэсийн үнэ 10 хувиар буурахад 410 тэрбум төгрөгөөр тус тус буурах тооцоо гарсан.

Экспортын орлогын хувьд нүүрсний биет хэмжээ 5 сая тонноор буурахад 1.2 их наяд төгрөгөөр, нүүрсний хил үнэ 10 хувиар буурахад 1.2 их наяд төгрөгөөр, зэсийн үнэ 10 хувиар буурахад 2.4 их наяд төгрөгөөр буурах эрсдэлтэй байна.

Эрсдэлийн магадлалын хувьд нүүрсний экспортын биет хэмжээ болон зэсийн үнийн бууралт бага, нүүрсний үнийн бууралт дунд түвшинтэй байна.

**Гурав.Байнгын шинжтэй зардлын дунд хугацааны санхүүжилт**

*2026 оны төсвийн тодотголоор төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, татаас болон бусад чиглэлээр шинээр бий болгосон буюу нэмэгдүүлсэн байнгын шинжтэй зардал тус бүрээр:*

**3.1.2026 онд шаардагдах санхүүжилтийн хэмжээ**

2026 төсвийн тодотголын төсөлд төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх арга хэмжээнд зориулж 844.6 тэрбум төгрөг нэмэгдүүлэн тусгасан. Харин татаасны хувьд суурь тэтгэвэрт зориулж 196.3 тэрбум төгрөг, мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулах зорилгоор 150.0 тэрбум төгрөг,

хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлж, эрчим хүчний тарифын алдагдалд 107.3 тэрбум төгрөг, эрчим хүчний салбарын их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлд 92.7 тэрбум төгрөг тус тус нэмэгдүүлэн тусгасан. Мөн боловсролын салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан 50.0 тэрбум төгрөгийг 2026 оны төсвийн тодотголын төсөлд тусгасан болно.

### 3.2.2027 оны бүтэн жилийн санхүүжилтийн хэрэгцээ

2027 оны төсвийн төсөлд төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 2026 онд 50 хувь нэмэгдүүлсний бүтэн жилийн төсвийн нөлөөлөлд 1,686.3 тэрбум төгрөг, 2027 оны 2-р улирлаас төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 10 хувь, төрийн захиргаа болон төрийн тусгай албан хаагчдын цалинг 20 хувь тус тус нэмэгдүүлэхтэй холбогдуулан 888.1 тэрбум төгрөг тус тус тусгасан. Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхэд 1,922.6 тэрбум төгрөг, нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулан 10 хувиар нэмэгдүүлэхэд 750.2 тэрбум төгрөг, нийт 2,672.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 2027 оны төсвийн төсөлд тусгасан. Мөн хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлж, эрчим хүчний тарифын алдагдалд 141.9 тэрбум төгрөг тусгасан.

### 3.3.2027 оны төсвийн төсөлд тусгасан хэмжээ

2027 оны төсвийн төсөлд төрийн албан хаагчдын цалин хөлсний зардлыг 9,190.3 тэрбум төгрөг байхаар тооцсон бөгөөд энэ хэмжээ дээр Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүждэг эмнэлгүүдийн цалингийн нөлөөллийг тусгавал нийт цалин хөлс 11,003.2 тэрбум төгрөг болж байна. Нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн нийт дүнг 10,221.9 тэрбум төгрөг байхаар 2027 оны төсвийн төсөлд тусгалаа.

### 3.4.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл болон бусад дагалдах зардлыг оролцуулсан нийт төсвийн өртөг

2026 төсвийн тодотголын төсөлд төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх арга хэмжээнд зориулж 844.6 тэрбум төгрөг нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбогдуулан ажил олгогч талаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 94.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тусгасан.

### 3.5.Улсын төсөв, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан болон бусад холбогдох төсөв, санд үзүүлэх нөлөөлөл

2026 оны төсвийн тодотголын төсөлд нэмэгдүүлэхээр тусгасан цалин, тэтгэвэр, татаас болон бусад байнгын шинжтэй зардлууд нь улс, орон нутгийн төсвийг 1,165.2 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн төсвийг 196.3 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг 79.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж байна.

### 3.6.Тухайн байнгын зардлыг санхүүжүүлэхээр тооцсон байнгын орлогын эх үүсвэр

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд суурь тэтгэврийг улсын төсвөөс олгохоор заасны дагуу 2026 оны төсвийн тодотголын төсөлд тусгасан 2026 оны 11 дүгээр сараас олгож эхлэх суурь тэтгэврийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар эрүүл

мэндийн салбарын ажилчдын цалинг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр, бусад зардлыг улс, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тооцсон.

*Мөн Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн тодотголд тусгасан төсвийн хэмнэлтийг дараах ангиллаар:*

**3.8.Бүтэц, орон тоо, чиг үүргийн бодит өөрчлөлтөөс бий болсон жил бүр давтагдах бүтцийн хэмнэлтийн хэмжээ**

2026 оны төсвийн тодотголын төсөлд төрийн албан хаагчдын орон тоог 2025 оны тодотголоор 9 хувь бууруулсан түвшинд хэвээр хадгалж, чиг үүрэг, орон тоо нэмэгдүүлэхгүй байх зарчмыг баримталсан. Түүнчлэн 2026 оны төсвийн тодотголын төсөлд бүтэц, орон тооны хэмнэлтээс үүдэлтэй зардлын нөлөөлөл байхгүй болно.

**3.9.Худалдан авалт, бараа үйлчилгээний зардлыг тогтвортой бууруулснаар бий болсон хэмнэлт**

2026 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 2026 оны тодотголын төсөлд бараа, үйлчилгээний бусад зардлыг 25.3 тэрбум төгрөгөөр бууруулсан.

**3.10.Тухайн төсвийн жилд хойшлуулсан, санхүүжүүлээгүй зардал**

"2026 оны төсвийн зардлын санхүүжилтэд эрэмбэ тогтоож, төсвийн хэмнэлт, мөнгөн хөрөнгийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2026 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 325 дугаартай тогтоолд төсөвт байгууллагын тэвчиж болох зарим зардлыг бууруулахаар заасан бөгөөд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн тодотголын төсөлд эдгээр зардлын санхүүжилтийг бууруулахаар тооцож төлөвлөсөн. Энэ хүрээнд төрийн цэргийн болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төсвийн байгууллагын тээвэр, шатахуун, дотоод албан томилолт, сургалт, дадлага, бэлтгэл, төрийн өндөр, дээд түвшний албан ёсны айлчлал болон өндөр түвшний зочин, төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолт, зочин төлөөлөгчийн зардлыг бууруулан тооцов. Мөн бүх шатны төсвийн байгууллагын эд хогшил, тавилга, автомашин, багаж, техник хэрэгсэл худалдан авах, урсгал засвар хийх, түүнчлэн нэн тэргүүний хэрэгцээнд хамаарахгүй бараа, ажил, үйлчилгээ болон мэргэжлийн үйлчилгээ худалдан авах зардлыг хязгаарлана. Ажил олгогчоос олгодог боловч хууль тогтоомжоор заавал олгохоор тогтоогоогүй нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн санхүүжилтийг мөн бууруулж тооцсон.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж заасны дагуу батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах, дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох зохицуулалт 2025 оноос хэрэгжиж эхэлсэн.

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 11.1.12 дахь хэсэгт тус тус заасны дагуу Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний мэдээллийг нэгтгэн боловсруулж, Засгийн газарт танилцуулсны дагуу “Төсвийн хэмнэлтэд тооцох тухай” Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн

02 дугаар тогтоол болон 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 231 дүгээр тогтоолыг тус тус баталж, 2025 онд 535.9 тэрбум төгрөг, 2026 онд 247.0 тэрбум төгрөг тус тус хэмнэлтэд тооцогдсоноор дараа онуудад ирэх төсвийн ачааллыг 2 их наяд төгрөгөөр бууруулсан.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.6 дахь заалтад "тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх" гэж заасан бөгөөд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээр дурдсан хэмнэлтийг тооцсоноор буюу гэрээ байгуулаагүй 32 төслийн 118.6 тэрбум төгрөг, багцад хуваарилан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч гэрээ байгуулаагүй 103.3 тэрбум төгрөг, худалдан авах ажиллагааны явцад бий болсон хэмнэлт 29.4 тэрбум төгрөг, 2026 онд хэрэгжих боломжгүй болсон, шүүхийн маргаан үүссэн 4 төслийг түр хойшлуулж 21.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зогсоосноор нийт 272.2 тэрбум төгрөгийн хэмнэлтийг тусгасан болно.

### 3.11.Гүйцэтгэл гараагүй болон бусад шалтгаанаар бий болсон нэг удаагийн хэмнэлт

2026 оны төсвийн тодотголын төсөлд иргэдийн орлогыг хамгаалах, эрчим хүчний найдвартай байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг төрийн байгууллагын тэвчиж болох болон зайлшгүй бус урсгал зардлыг бууруулах, хэрэгжээгүй болон үр ашиг багатай арга хэмжээний санхүүжилтийг дахин хуваарилах замаар шийдвэрлэхээр зорьсон.

Энэ хүрээнд төрийн цэргийн болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төсвийн байгууллагын тээвэр, шатахуун, дотоод албан томилолт, сургалт, дадлага, бэлтгэл, төрийн өндөр, дээд түвшний албан ёсны айлчлал болон өндөр түвшний зочин, төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолт, зочин төлөөлөгчийн зардал, бүх шатны төсвийн байгууллагын эд хогшил, тавилга, автомашин, багаж, техник хэрэгсэл худалдан авах, урсгал засвар хийх, түүнчлэн нэн тэргүүний хэрэгцээнд хамаарахгүй бараа, ажил, үйлчилгээ болон мэргэжлийн үйлчилгээ худалдан авах зардлыг хязгаарлаж, ажил олгогчоос олгодог боловч хууль тогтоомжоор заавал олгохоор тогтоогоогүй нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн санхүүжилтийг бууруулсан. Үүний зэрэгцээ 2026 оны төсөвт санхүүжилт нь батлагдсан боловч хэрэгжилт эхлээгүй, тухайн төсвийн жилд бодит үр дүнд хүрэх боломж хязгаарлагдсан, эсхүл бодлогын ач холбогдлоор эрэмбэлэхэд хойшлуулах боломжтой зарим хөтөлбөр, арга хэмжээний зардлыг бууруулахаар тооцсон.

### 3.12.Шинээр бий болгосон байнгын зардлын бүтэн жилийн зардлын тооцоо болон жил бүр давтагдах бүтцийн хэмнэлтийн харьцуулалт, дунд хугацааны санхүүжилтийн зөрүү

2026 оны төсвийн тодотголын төсөлд байнгын шинжтэй зардал болох төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх арга хэмжээнд зориулж 844.6 тэрбум төгрөг, ахмад настнуудад олгох суурь тэтгэврийн зардалд 196.3 тэрбум төгрөгийг тус тус нэмэгдүүлэн тусгасан. 2026 оны төсвийн тодотголын төсөлд тусгаад байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 50 хувь нэмэгдүүлэх арга хэмжээний бүтэн жилийн төсвийн нөлөөлөл 1,686.3 тэрбум төгрөг, 2026 оны 11 дүгээр сараас олгож эхлэх ахмадын суурь тэтгэврийн бүтэн жилийн нөлөөлөл нь 1,216.4 тэрбум төгрөг байх бөгөөд эдгээр зардлуудын нөлөөллийг 2027 оны төсвийн төсөлд бүрэн тусгасан.

## Дөрөв. Төсвийн тусгай шаардлагын хэрэгжилт

*Засгийн газраас 2027 оны төсвийн төсөлтэй хамт Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн өмчит компаниудын нэмэлт ногдол ашиг, Оюутолгой төслийн ногдол ашиг, орон нутгийн үнэт цаас, урьд оны төсвийн үлдэгдэл болон бусад тодорхой эх үүсвэрийн хэмжээгээр нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэх, 2027 онд төсвийн зарлагын өсөлтийн зарим тусгай шаардлагыг хамаарахгүй байхаар зохицуулалт санал болгосон байна. Үүнтэй холбогдуулан:*

### 4.1.Нэмэлт орлого, эх үүсвэр тус бүрийн хэмжээ, тогтвортой болон нэг удаагийн шинж

Ногдол ашгийн нийт орлого 2024 онд 535.7 тэрбум, 2025 онд 571.8 тэрбум төгрөг байсан. Үүнээс улсын төсөвт тус тус 40.1 тэрбум, 64.7 тэрбум төгрөг төвлөрсөн байна. 2027 оны төсвийн төсөлд төлөвлөсөн 6.5 их наяд төгрөгийн орлогын 3.5 их наяд төгрөгийг төрийн өмчит компаниудаас бүрдүүлэхээр тооцсон. Үүнээс 2.5 их наяд төгрөгийг төрийн өмчит компаниудын өмнөх жилүүдийн ногдол ашгийн өрийг барагдуулах замаар улсын төсөвт төвлөрүүлнэ. Үлдэх 1.0 их наяд төгрөгийг компаниудын 2026 оны цэвэр ашгаас хуваарилах ногдол ашгаар бүрдүүлэхээр тооцсон. Энэ нь жил бүрийн ашигт ажиллагаанд үндэслэн давтагдах боломжтой. Үлдсэн 3 их наяд нь Оюу толгой төслөөс Монгол Улсын талд ногдох ногдол ашиг юм.

### 4.2.Эдгээр орлого, эх үүсвэрээр байнгын шинжтэй урсгал зардал санхүүжүүлэхээр төлөвлөсөн эсэх

2026 оны төсвийн тодотголын төсөлд нэмэгдүүлэхээр тусгасан цалин, тэтгэвэр, татаас болон бусад байнгын шинжтэй зардлууд нь улс, орон нутгийн төсвийг 1,165.2 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн төсвийг 196.3 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг 79.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж байна.

### 4.3.Нэмэлт орлого бий болсон хэмжээгээр төсвийн зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэх нь мөчлөг сөрсөн төсвийн бодлогын зарчимтай нийцэж байгаа эсэх талаарх тооцоо, дүгнэлт

Экспортын орлого, гадаад худалдааны ашиг нэмэгдэж байгаа нь эдийн засгийн гадаад орчны хувьд эерэг үзүүлэлт хэдий ч төсвийн бодлогын мөчлөгийн шинжийг зөвхөн эдгээр үзүүлэлтээр тодорхойлох нь учир дутагдалтай. Учир нь эдийн засгийн өсөлтийн эх үүсвэр, дотоод эрэлтийн нөхцөл, уул уурхайн бус салбарын идэвхжил зэрэг хүчин зүйлсийг хамтад нь авч үзэх шаардлагатай.

2026 оны эхний 8 сарын байдлаар экспортын орлого 14.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 57.2 хувиар өссөн бөгөөд экспортын өсөлтийн 95.7 хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байна. Үүний нөлөөгөөр гадаад худалдааны тэнцэл 6.0 тэрбум ам.долларын ашигтай, төлбөрийн тэнцэл эхний 7 сарын байдлаар 826.0 сая ам.долларын ашигтай гарсан нь гадаад секторын нөхцөл байдал харьцангуй таатай байгааг илтгэж байна.

Гэсэн хэдий ч гадаад секторын эерэг үзүүлэлт нь эдийн засгийн дотоод суурь нөхцөл сайжирсныг дангаараа илэрхийлэхгүй. Тухайлбал, 2026 оны II улиралд эдийн засгийн өсөлт 7.7 хувьд хүрсэн боловч уг өсөлтийн 3.9 нэгж хувийг уул уурхайн салбар дангаараа бүрдүүлсэн. Харин аж үйлдвэр, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга, цахилгаан, ус хангамж зэрэг уул уурхайн бус салбаруудын өсөлтийн оролцоо өмнөх оны мөн үеэс буурсан байна. Мөн уул уурхайн бус салбарын гарцын зөрүү сөрөг түвшинд байгаа нь эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчин чадал бүрэн ашиглагдахгүй байгааг харуулж байна. Түүнчлэн, эрэлтийн буюу эцсийн ашиглалт талаас эдийн засаг 2026 оны эхний хагас жилд 7.8 хувиар өссөний 13 нэгж хувийг гадаад эрэлт бүрдүүлсэн бол дотоод эрэлт 5.2 нэгж хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг хязгаарласан байна.

Үүний зэрэгцээ манай улсын дотоод эрэлт мөн харьцангуй сул байна. Тухайлбал, өрхийн хэрэглээний өсөлт 2026 оны II улирлын байдлаар 0.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 нэгж хувиар буурсан бол өрхийн бодит орлого 2.8 сая төгрөгт хүрч, 4.8 хувиар буурсан байна. Мөн сүүлийн саруудад инфляц нэмэгдэж байгаа нь өрхийн бодит худалдан авах чадварт нэмэлт дарамт үзүүлж байна.

Уг нөхцөлд гадаад салбарын таатай нөхцөл байдал нь төсвийн бодлогыг заавал хумих үндэслэл болохгүй. Харин төсвийн бодлогыг уул уурхайн салбарын өсөлтөөс гадуурх эдийн засгийн идэвхжил, дотоод эрэлт, өрхийн бодит орлого сул байгаа хэсэгт чиглүүлэх шаардлага үүсэж байна. Энэ утгаараа төсвийн зарлага болон алдагдлыг нэмэгдүүлж байгаа эсэхээс илүүтэйгээр төсвийн бодлогыг нийгэм, эдийн засгийн аль салбарт чиглүүлж, эдийн засгийн ямар нөхцөлд хэрэгжүүлж байгаа нь төсвийн бодлогын мөчлөг сөрсөн шинжийг тодорхойлно.

Тиймээс 2026 оны хувьд уул уурхайн салбарын өсөлт, экспортын орлогын нэмэгдлийг эдийн засгийн нийт эрэлт хүчтэй байна гэж шууд дүгнэхээс илүүтэй, эдийн засгийн өсөлтийн бүтцийн ялгаатай байдал, уул уурхайн бус салбарын сул идэвхжил, өрхийн бодит орлогын бууралт, дотоод эрэлтийн сааралтыг харгалзан үзэх нь зүйтэй. Энэ нөхцөлд эдийн засгийн сул хэсэгт чиглэсэн төсвийн дэмжлэг нь мөчлөг сөрсөн төсвийн бодлогын зарчимтай нийцнэ гэж үзэж байна.

### 4.4.Тухайн орлогыг төсвийн алдагдал, Засгийн газрын өрийг бууруулах, төсвийн болон баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд ашиглах хувилбарын тооцоо

**Үндэсний баялгийн санг нэмэгдүүлэх:** Монгол Улсын 2027 оны төсвийн жилд Оюу толгой төслийн үйл ажиллагаанаас Монгол Улсын Засгийн газарт буюу төрд ногдох ногдол ашгийн орлого нэмэгдсэнээр нэн тэргүүнд эрчим хүчний салбарын болон нийгмийн бусад тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, улмаар үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулах, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглүүлэх бөгөөд энэхүү ногдол ашгийн орлогоос нийгмийн тулгамдсан асуудлуудад хөрөнгө оруулалт хэлбэрээр хуваарилаад үлдэх хэсгийг Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн нэг болох Хуримтлалын санд хуваарилахаар Нийгмийн болон суурь дэд бүтцийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тусгасан.

Ингэснээр Оюу толгой төслийн ногдол ашгаас ирэх оны төсвийн жилд иргэн бүр хүртэх нөхцөл бүрдэх бөгөөд тус төслийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос Үндэсний баялгийн санд төвлөрүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан газрын хэвлийн баялгийн үр

өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх үзэл санаа бодитоор хэрэгжих юм.

**4.5.2027 онд төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлага хамаарахгүй байх эдийн засаг, төсвийн бодлогын үндэслэл**

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028–2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд туссан үзүүлэлтүүд болон дагалдуулан өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд нийцүүлэн боловсруулж, өргөн мэдүүлсэн болно.

**4.6.Хүчин төгөлдөр төсвийн тусгай шаардлагыг өөрчлөхгүйгээр 2027 оны төсвийн төслийг боловсруулсан тохиолдолд нийт зарлагад шаардагдах бууралтын хэмжээ**

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028–2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байхаар тусгасан.

Иймд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд нийцүүлж, Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөлд нийт орлогыг 41.3 их наяд, нийт зарлагыг 43.6 их наяд, тэнцвэржүүлсэн тэнцлийг -2.3 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувийн алдагдалтай байхаар тооцож, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

**4.7.Төсвийн төсөл өргөн мэдүүлэхтэй зэрэгцүүлэн хүчин төгөлдөр төсвийн тусгай шаардлагад үл хамаарах буюу түүнийг сулруулах зохицуулалт санал болгож байгаа нь төсвийн сахилга, дунд хугацааны тогтвортой байдал, төсвийн дүрмийн итгэлцэлд үзүүлэх нөлөөллийн эрх зүй, төсвийн бодлогын үнэлгээ**

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028–2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд туссан үзүүлэлтүүд болон дагалдуулан өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд нийцүүлэн боловсруулж, өргөн мэдүүлсэн.

**Тав.Монгол Улсын Их Хурлын 52, 54 дүгээр тогтоолын хэрэгжилт**

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлаас Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газар Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд хүргүүлж, тайлагнаж ирсэн.

Улсын Их Хурлын 2024 оны 52, 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах талаар асуудлыг Сангийн сайд Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанд танилцуулсны дагуу хуралдааны тэмдэглэлээр Засгийн газрын холбогдох гишүүн, албан тушаалтанд тодорхой үүрэг, даалгавар өгсөн бөгөөд эдгээр тогтоолууд нь дээр дурдсан Улсын Их Хурлын шийдвэрт хамаарах буюу биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан болно.

Таны асуулгатай холбогдуулан тогтоолуудын хэрэгжилттэй холбогдох өнөөгийн байдлын талаарх мэдээллийг дараах байдлаар танилцуулж байна:

**5.1.Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилт:**

| |
|---|
| **1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх:** |
| **1.1.ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олгох, бүртгэх, шилжүүлэх, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим санг бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага, татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох** |

*Хэрэгжилт:*

Ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн төрөлжсөн цахим сан үндсэндээ бүрдсэн бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн кадастрын систем, Геологи, уул уурхайн мэдээллийн систем, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн цахим хаягууд ажиллаж, мэдээллийг нэгтгэж байна. Уул уурхайн кадастрын системийг Улсын нэгдсэн бүртгэлийн төрөлжсөн мэдээллийн системд нэгтгэснээр ил тод байдлыг хангаж, Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд холбогдсон байна.

Түүнчлэн, Ашигт малтмал, газрын тосны газрын нэгдсэн систем, Татварын удирдлагын нэгдсэн систем хооронд автоматаар мэдээлэл солилцох сервис холболтын хөгжүүлэлт хийгдэж байгаа буюу татварын албанаас хүргүүлэх мэдээллийн сервис 2026 оны 5 дугаар сард бүрэн дууссан бол Ашигт малтмал, газрын тосны газраас татварын албанд хүргүүлэх мэдээллийн сервис холболт хийгдэж байна. Сервис холболт бүрэн хэрэгжих хүртэл системд нэвтрэх эрх олгон, үйл ажиллагаандаа ашигласнаар татвар төлөгчдөд хүндрэл чирэгдэл учруулахгүй үйлчлэх боломж бүрдсэн.

| |
|---|
| **1.2.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх** |

*Хэрэгжилт:*

Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2026

оны 06 дугаар сарын 26-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталж, нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 50 сая төгрөгөөс 400 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн.

Тус хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд төсөвт 160 тэрбум төгрөгийн нөлөөлөл үзүүлэх тооцоололтой болно.

**1.3.улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийх, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах**

*Хэрэгжилт:*

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 315 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэх саналыг Сангийн яаманд ирүүлсэн. Эдгээр төслүүдийн хувьд тарифт цалин, материалын үнийн өсөлт, анх төлөвлөсөн зураг төсвийн алдаатай байдал, захиалагч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр төсөвт өртөг нэмэгдсэн байна.

Дээрх төслүүдээс магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан 249 төсөл, арга хэмжээний 644.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий мэдээллийг 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн Монгол Улсын Ерөнхий аудиторт үндэслэлтэй эсэхийг нягтлан шалгуулахаар холбогдох мэдээллийг 8 удаагийн албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний аудитын газраас эдгээр төслүүдийн магадлалын ерөнхий дүгнэлт үндэслэлтэй эсэхэд хяналт шалгалт хийсний дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар нийт 125 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 235.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Мөн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар шийдвэрлэгдээгүй 23 төсөл, арга хэмжээний нэмэгдэл санхүүжилт болох 50.8 тэрбум төгрөгийг Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгасан болно.

Түүнчлэн, Барилга, хот байгуулалтын сайд (хуучнаар)-ын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай” 95 дугаар тушаалаар барилгын ажилтны тарифт цалингийн жишгийг шинэчилсэн, мөн холбогдох салбарын норм, нормативын өөрчлөлтөөс үүдэн төсвийн ерөнхийлөн захирагчдаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй нийт 117 төсөл, арга хэмжээнд 77.8 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн нэмэгдлийн саналыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгуулахаар ирүүлсэн. Дээрх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1.1 дэх заалтад барилга, эрчим хүч, зам, тээврийн салбарын норм, нормативын сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж, холбогдох хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан болно.

**2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн,**

| |
|---|
| **санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:** |
| **2.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран тэдгээрийн засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах** |

*Хэрэгжилт:*

Төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдал, үйл ажиллагааны үр ашгийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах, хөрөнгийн үнэ цэнийг өсгөх, гадаадын хөрөнгө оруулалт татах зорилгоор төрийн эзэмшлийн хувьцааг багцлан төвлөрүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах үндэсний хөрөнгө оруулалтын сан байгуулах бэлтгэл ажлыг хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд сан байгуулах эрх зүйн болон зохион байгуулалтын шийдлийг тодорхойлох, санд шилжүүлэх төрийн өмчит компаниудын төрийн эзэмшлийн хувьцааны багцыг бүрдүүлэх, энэ чиглэлээр олон улсын хөрөнгө оруулалтын менежментийн байгууллагатай хамтран ажиллах санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 135 дугаар захирамжаар байгуулан ажиллуулж байна.

Ажлын хэсгээс сан байгуулах бэлтгэл ажлын явц, төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанд тухай бүр танилцуулж, нийт 2 тэрбум ам.доллароос доошгүй хэмжээний төгрөгөөр үнэлэгдэх төрийн өмчит компаниудын төрийн эзэмшлийн хувьцааг санд шилжүүлэх, багцад хамруулах компанийн жагсаалтыг өмчлөлийн бодлогод тусгах, сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын нэр хүнд бүхий мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх бэлтгэлийг хангаж байна.

Олон улсын мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах хүрээнд 2026 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Франклин Темплетон компанитай, 2026 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр БлэкРок Файнэншл Менежмент, Инк. компанитай харилцан ойлголцлын санамж бичиг тус тус байгуулсан.

Ажлын хэсгээс сангийн хөрөнгийн удирдлагыг гүйцэтгэх мэргэжлийн байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах баримт бичгийн төслийг боловсруулж байна.

Төлөвлөж буй бүтцээр төрийн өмчит компаниудын төрийн эзэмшлийн хувьцааг үндэсний хөрөнгө оруулалтын санд багцлан төвлөрүүлж, мэргэжлийн удирдлагаар ханган, сангийн үнэт цаасыг дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд үе шаттай арилжаалах замаар хөрөнгө оруулалт татна.

Дээрхтэй холбогдуулан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан бөгөөд төсөлд сангийн хөрөнгийн удирдлагыг хамтран ажиллах санал ирүүлсэн олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын менежментийн компаниудаас холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр тусгасан болно.

**2.2.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах асуудлыг судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах**

*Хэрэгжилт:*

Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, чиг үүргийн давхардлыг арилгах, удирдлагын болон үйл ажиллагааны зардлыг бууруулах чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Засгийн газрын 2026 оны 251 дүгээр тогтоолоор "Эрдэнэс Монгол" нэгдлийн хэмжээнд 4 хуулийн этгээдийг холбогдох компанид нэгтгэх, 3 хуулийн этгээдийг татан буулгах, хамтарсан хөрөнгө оруулалттай 7 хуулийн этгээдийн хувьцааг шилжүүлэх, татан буулгахаар шийдвэрлэж, толгой компанийн засаглал, бүтэц, чиг үүргийг шинэчлэн тогтоон, нэгдлийн компанийн бүтцийг оновчтой болгох арга хэмжээг эхлүүлсэн.

Мөн Засгийн газрын 2026 оны 363 дугаар тогтоолоор 21 төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийтийн үйлчилгээний төрийн өмчийн компани, 36 төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийтийн үйлчилгээний байгууллага болгон өөрчлөн байгуулах, 4 төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгахаар шийдвэрлэсэн.

Энэ хүрээнд хуулийн этгээдийн чиг үүргийн давхардлыг арилгах, удирдлагын шат дамжлага, зардлыг бууруулах, бүтэц, орон тоог үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй уялдуулан оновчтой тогтоох зарчмыг баримтлан зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт үүрэг болгон, хэрэгжилтийг шуурхай хангуулахаар ажиллаж байна.

Энэхүү бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлснээр байгууллагуудын удирдлагын бүтэц, орон тоо, үйл ажиллагааг оновчилж, улсын төсөвт жил бүр 25-30 тэрбум төгрөгийн хэмнэлт бий болгох боломжтой гэсэн урьдчилсан тооцоо гарсан болно.

**2.3.төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах асуудлын талаар холбогдох санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх**

*Хэрэгжилт:*

Улсын Их Хурлаас 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг боловсруулж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 168 дугаар захирамжаар Ажлын хэсэг байгуулж, өмчлөлийн бодлогын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Өмчлөлийн бодлогын хүрээнд төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдал, үр ашгийг дээшлүүлэх, төрийн өмчийн оролцоог оновчтой болгох зорилгоор хувьцааг нь хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах асуудлыг тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**2.4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох**

*Хэрэгжилт:*

Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д 2026 оны 1 дүгээр улиралд 5,600 гаруй нийтийн мэдээлэл хариуцагч байгууллага бүртгэл үүсгэх, тайлангаа илгээхээс 4,778 байгууллага буюу 85.3 хувь нь бүртгүүлж, 2,608 байгууллага буюу 54.6 хувь нь тайлангаа илгээсэн бол 2026 оны 2 дугаар улиралд 5,332 мэдээлэл хариуцагч байгууллага буюу 95.2 хувь нь бүртгэл үүсгэж нээлттэй мэдээллийн системд мэдээллээ илгээх эрхтэй болсон байна. Үүнээс нийт 3,230 мэдээлэл хариуцагч байгууллага буюу 60.6 хувь нь хуулийн хугацаанд тайлан илгээсэн нь өмнөх улирлаас 6 хувиар, бүртгүүлсэн байгууллага 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах хүрээнд нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар 68 байгууллага мэдээллээ илгээж, улирлын дундаж үнэлгээ 60.64 хувь байсан бол 2 дугаар улиралд нийт 69 байгууллага тайлангаа ирүүлж 70.23 хувьтай үнэлэгдсэн байна.

Түүнчлэн, “Чиглэл хүргүүлэх тухай” Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2026 оны А-1/408 дугаар албан бичгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захирал нарт болон аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн харилцааны байгууллагын дарга нарт Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газраас баталсан “Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-д олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах, тайланг хагас, бүтэн жилээр ирүүлэх чиглэлийг өгч ажилласан байна.

**2.5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын эээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх**

*Хэрэгжилт:*

Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан бол Нийтийн өмчийн хуулийн төсөл анхны хэлэлцүүлэгт бэлтгэгдэж байгаа болно.

**2.6.Төрийн банк болон санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүргээр шинэчлэн зохион байгуулж, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй төсөл, хөтөлбөр, хэрэглээг урамшуулан дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэх**

*Хэрэгжилт:*

**Төрийн банк:**

Төрийн банк нь ногоон банкны үйл ажиллагааг олон улсын стандартын жишигт нийцүүлэн хөгжүүлэх хүрээнд Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, Тогтвортой хөгжлийн журмыг хэрэгжүүлж, банкны бүтцэд Тогтвортой хөгжлийн албыг бие даасан нэгжээр зохион байгуулан, Тогтвортой хөгжлийн хороогоор ногоон хөгжил, ногоон эдийн засгийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх засаглалын тогтолцоог бүрдүүлсэн.

Ногоон болон тогтвортой санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд малчны ногоон зээл, ногоон бэлтгэн нийлүүлэгчийн зээл, бизнесийн ногоон зээл, ногоон орон сууцны зээл, эко тээврийн хэрэгслийн зээл, ахуйн хэрэглээний ногоон зээл зэрэг бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгон ажиллаж байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг өргөжүүлж, "Ногоон хадгаламжийн сертификат", "Гялс төгөл" үйлчилгээг шинээр нэвтрүүлэн, ахуйн хэрэглээний ногоон болон эко тээврийн хэрэгслийн зээлийн хугацааг 60 сар хүртэл уртасгаж, санхүүжилтийн нөхцөл, хүртээмжийг сайжруулсан.

Үүний үр дүнд 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн багц 422.2 тэрбум төгрөг буюу нийт зээлийн багцын 9.48 хувь, үүнээс ногоон зээлийн багц 161.9 тэрбум төгрөг буюу 3.64 хувьд хүрч, 2,858 зээлдэгчийг хамруулсан байна. Ногоон зээлийн багцын томоохон хэсгийг эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны зээл 84.6 тэрбум төгрөг, малчны ногоон зээл 37.2 тэрбум төгрөг, эко тээврийн хэрэгслийн зээл 14.7 тэрбум төгрөг тус тус бүрдүүлж байна.

Ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүрээнд олон улсын зах зээлээс 3 жилийн хугацаатай 200 сая ам.долларын бондын эх үүсвэр татаж, үүнээс 50 сая ам.долларыг тогтвортой, ногоон хөгжлийг дэмжсэн байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн. 2026 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар тогтвортой хөгжилд чиглэсэн нийт эх үүсвэр 554.4 тэрбум төгрөг буюу бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 8.5 хувьд хүрсэн байна.

Мөн ногоон барилга, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, 4,200 айлын ногоон орон сууцны төсөлд оролцож, олон улсын LEED Gold Pre-certification гэрчилгээтэй "NEOCITY" хотхон төслийг ногоон орон сууцны зээлээр санхүүжүүлэх хамтын ажиллагааг эхлүүлсэн. Түүнчлэн ногоон санхүүжилтийн эрсдэлийн хамгаалалтыг нэмэгдүүлэх хүрээнд "Ногоон даатгал" бүтээгдэхүүнийг хэрэгжүүлж, 2026 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар 102.5 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 1,150 зээлийг ногоон даатгалд хамруулсан байна.

**Монголын хөрөнгийн бирж:**

Хөрөнгийн зах зээлд Байгаль орчин, нийгэм, засаглал (цаашид "БОНЗ" гэх)-ын тайлагнал, ил тод байдлыг сайжруулах хүрээнд бүртгэлтэй компаниудад БОНЗ-Тогтвортой байдлын тайлагналын удирдамж, Тогтвортой байдлын олон улсын стандартын зөвлөлийн тогтвортой байдлын тайлагналын шаардлага, БОНЗ-ын индикаторуудыг хэмжих, шаардлагатай мэдээлэл цуглуулах аргачлалын талаар сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлж, 30 гаруй компанийн 50 орчим төлөөллийг хамруулсан.

БОНЗ-ын тайлагналыг мөрдүүлэх ажлын хүрээнд биржид бүртгэлтэй 34 компани БОНЗ-Тогтвортой байдлын тайлангаа ирүүлснийг олон нийтэд нээлттэй байршуулсан. БОНЗ-ын мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор БОНЗ-ын мэдээллийн санг хөгжүүлж, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудастай холбох ажлыг хэрэгжүүлж байна. Ингэснээр бүртгэлтэй компаниудын БОНЗ-ын мэдээлэл, тогтвортой байдлын тайланг монгол, англи хэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад нэгдсэн байдлаар хүргэх боломж бүрдэнэ.

Мөн дотоодын нээлттэй ногоон болон тогтвортой бондын зах зээлийг дэмжих хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи, Монгол Улсын ногоон таксономи болон олон улсын холбогдох стандарт, шалгуурт нийцсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх үнэт цаас гаргагчид хувьцааны ангиллын болон өрийн хэрэгслийн зарим шалгуураас чөлөөлөх, хөнгөлөх хүсэлт гаргах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн дээрх шаардлагыг хангасан үнэт цаасны бүртгэлийн үйлчилгээний хөлсийг 20 хүртэл хувиар хөнгөлөх зохицуулалтыг "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д тусган хэрэгжүүлж байна.

| |
|---|
| **3.Төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх:** |
| **3.1."бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж" гэсэн тухайн төрийн байгууллагын өөрсдөө хийх боломжгүй, тусгай мэргэшил, ур чадвар шаардагдах, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг тухайн ажлын төрөл, цар хүрээ, мэргэжлийн ур чадвар, зах зээлийн үнэлгээнд үндэслэн Засгийн газрын санхүүгийн статистик гаргах аргачлал, загварт нийцүүлж, зардлын эдийн засгийн зүйл болон зориулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ангиллаар нарийвчлан тодорхойлох, цаашид жилийн төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралтад нэмэлтээр тусгах** |
| **3.2.төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн ерөнхийлөн захирагчид "бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж" болон "бусад зардал" гэсэн зардлын ангиллаар төсөв зарцуулах болсон зайлшгүй шаардлага, гарах үр дүн, үр ашгийг тооцож байх** |
| **3.3.олон улсын сайн туршлагад үндэслэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд хуулиар хязгаарлалт тогтоох, уг зардалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах, аудитын тайлангаар баталгаажуулах, олон нийтэд нээлттэй мэдээлэх асуудлын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох** |

*Хэрэгжилт:*

2015 онд баталсан эдийн засгийн ангилалд нийтлэг байдлаар нарийвчлан ангилах боломжгүй зарлагууд, тухайлбал гуравдагч этгээдтэй үйлчилгээ үзүүлэхэд төлөх төлбөртэй холбоотой зарлагууд зэрэг байсан. Тиймээс бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний ангиллыг нарийвчлан задалж холбоотой ангиллуудад шилжүүлэх, шаардлагатай зарим ангиллыг шинээр тусгах, нэршлийг тодорхой болгож өөрчлөх зэрэг зохицуулалтыг хийн Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалаар эдийн засгийн ангиллыг шинэчлэн баталсан. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг үйлчилгээний зардлыг судалгаа хөгжүүлэлт, хөрөнгийн ашиглалтын менежмент, харилцаа холбоо, мэдээлэл сурталчилгаа, хот тохижилт, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ болон мэргэжлийн үйлчилгээ гэсэн 8 ангилалд дахин хуваарилсан болно.

Шинэчилсэн ангиллыг Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэх үеэс буюу 2025 оны 8 дугаар сараас эхлэн ашигласан бол гүйцэтгэл, тайлагналтад 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ашиглаж байна.

Энэхүү зохицуулалтын үр дүнд 2026 оны төсөвт "бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний бусад төлбөр" ангилалд төлөвлөгдсөн 1.2 их наяд төгрөгийн төсвийн 63 хувийг зохих өөр эдийн засгийн ангилалд шилжүүлсэн.

Судалгаа, шинжилгээний тухайд 2022-2025 онуудад нэгдсэн төсвийн хэмжээнд төрийн сангаар хийгдэж буй бараа үйлчилгээний болон бараа үйлчилгээний бусад зарлагын 1.0 сая гаруй гүйлгээг бүртгүүлэн, 242.1 мянган этгээдэд шилжүүлсэн 4.8 их наяд төгрөгийн гүйлгээний утгыг шинжилсэн болно.

**4.Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын программ хангамж, тоног төхөөрөмжийн худалдан авалт, ашиглалтыг сайжруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, салбар хоорондын цахимжилтыг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:**

**4.1.төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдал болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдалд аудит хийж тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах**

*Хэрэгжилт:*

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 4,119 байгууллагад 2000 оноос хойш бүртгэгдсэн биет бус хөрөнгийн дүнгээс 269.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 13,526 программ хангамж судалгаанд хамрагдсанаас 92.2 хувь нь хэвийн бүртгэлтэй байна.

Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2025 онд төрийн нийт 134 байгууллага эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан бөгөөд эдгээрээс 89-д нь газар дээр нь, 45-д нь систем ашиглан эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.

Засгийн газрын 2022 оны 493 дугаар тогтоолоор баталсан Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн 1 дүгээр үе шатны хэрэгжилт 85 хувьтай үнэлэгдсэн бөгөөд цаашид Үндэсний хэмжээнд кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах дүгнэлт гарсан байна.

**5.Нийслэл Улаанбаатар хотоос шилжин байрших боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжид байрлуулах, нийслэлд чөлөөлөгдөх барилга байгууламжийн тоо байршил, зориулалтыг судлан жагсаалт гаргаж, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд холбогдох Байнгын хороонд танилцуулж, шийдвэр гарсны дараа тэднийг худалдах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах**

*Хэрэгжилт:*

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгүүдийн жагсаалт, холбогдох танилцуулгыг бэлтгэн, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралд 2025 оны 06 дугаар сард танилцуулсан. Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 3 дугаар хуралдааны тэмдэглэлээр "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн эзэмшлийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахыг "Эрчис ойл" ХХК-д шилжүүлэх асуудлыг судалж зохих журмын дагуу шийдвэрлэх үүргийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн эзэмшлийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахыг худалдах асуудлыг зогсоосон болно. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-д бүртгэлтэй "Алтандорнод Монгол" ХХК-аас улсын төсвийн татварын өрөнд хураан авсан, ашиглагдахгүй байгаа үл хөдлөх хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр (4 дэх удаа зарласан) зохион байгуулсан. Хуулийн дагуу 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдөр 2501 дугаар бүхий "Худалдах, худалдан авах" гэрээг ялагч этгээдтэй байгуулсан бөгөөд гэрээний дагуу нийт үнэ болох 1,109,217,920.00 (нэг тэрбум нэг зуун есөн сая хоёр зуун арван долоон мянга есөн зуун хорь) төгрөгийг хуулийн хугацаанд бүрэн төлсөн тул "Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ"-г олгосон.

**6.Төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудыг нэгтгэн судалж, 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах**

*Хэрэгжилт:*

Сангийн яамнаас төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудын нэгдсэн судалгааг хийж гүйцэтгээд байна. Өөрөөр хэлбэл нэгдсэн төсвийн тэнцэлд нөлөө үзүүлэхүйц хэмжээний улсын төсвөөс зардлыг нь санхүүжүүлэхээр хууль тогтоомжид тодорхой тусгасан 55 хуулийн 70 зүйл, 84 заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Засгийн газарт чиглэл өгсөн бөгөөд төсвийн зарлагад нөлөөлж буй 2 зарлиг, улсын төсвөөс зардлыг нь санхүүжүүлэх болон зардлыг нь дотоодын нийт бүтээгдэхүүний тодорхой хувьтай тэнцэхээр тодорхойлсон Улсын Их Хурлын 11 тогтоол байна.

Судалгааны үр дүнг Улсын Их Хурлын даргын 2024 оны 263 дугаар захирамжаар байгуулсан “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсвийн төслийг боловсруулах болон төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх журмын талаар санал, дүгнэлт гаргаж, төсвийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах чиглэлээр хуулийн төсөл боловсруулж танилцуулах үүрэг бүхий ...” Ажлын хэсэг болон Дэд ажлын хэсэгт 3 удаа, Төрийн хэмнэлт, бүтээмжийн үндэсний зөвлөл (хуучнаар)-д 1 удаа тус тус танилцуулсан.

**7.Төсвөөс олгож байгаа бүх төрлийн татаас, урамшууллын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөлд судалгаа, шинжилгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, төсвийн ачааллыг бууруулах зорилтуудыг уялдуулах санал боловсруулж, 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах**

*Хэрэгжилт:*

Төсвийн зарлагын татаас, урамшууллын зардлын дийлэнх хувийг эзэлдэг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дотоодын хангамжийг бүрдүүлэх зорилгоор олгодог хөдөө аж ахуйн салбарын татаас, урамшуулал, тэр дундаа улаанбуудайн салбарын татаас, урамшууллын нөлөөллийг тооцох судалгааны ажлыг Дэлхийн банкны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэж байна.

**8.Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төвүүдийг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх**

*Хэрэгжилт:*

Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 22 дугаар тогтоолоор 29 үндэсний хороо, зөвлөлийг татан буулгаж, ажлын албаны орон тоог 146-аар бууруулсан.

**9.Цэвэр эрчим хүч үйлдвэрлэх, хогноос сэргээгдэх эрчим хүч гаргаж авах асуудлыг зохицуулах, ногоон эрчим хүч, эдийн засгийг дэмжих хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх**

*Хэрэгжилт:*

Хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаа нь Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Хог хаягдлын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдаж байна. Биомасс, ургамал болон органик гаралтай хаягдал нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт хамаарах бол ахуйн болон барилгын зэрэг нөхөн сэргээгдэхгүй хог хаягдлыг шатаах замаар эрчим хүч үйлдвэрлэх нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт хамаарахгүй.

Хог шатаах аргаар эрчим хүч үйлдвэрлэх чиглэлээр Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар нийт 6 компанийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэн баталснаас 4 компани тусгай зөвшөөрөл авсан

бөгөөд 2 компани “Диспетчерийн үндэсний төв” ХХК-тай цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээ байгуулсан байна.

**10.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх**

*Хэрэгжилт:*

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлуулсан.

Хуулийн энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр бүх аймагт түншлэлээр төсөл хэрэгжүүлэх боломжийг нээх, хувийн хэвшлийн түншлэгч төслийн саналаа түншлэлийн төвд шууд гаргаж урьдчилсан үнэлгээ хийлгэх, төрийн үйлчилгээний зарим төсөлд техник, эдийн засгийн үндэслэлийг төслийн онцлогоос хамааруулан шаардахгүй байх, төсөл санаачлагч өөрийн санхүүжилтээр техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан бол төслийн баг техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах, төрийн болон орон нутгийн өмчид хамаарах оюуны өмчийг түншлэлийн төсөлд нэвтрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах, олсон орлогоо инновац, судалгаа хөгжүүлэлтэд зарцуулах боломжийг нээх, урьдчилсан болон уралдаант шалгаруулалтыг нэгтгэж нэг үе шаттай болгох, шат дамжлагыг багасгах, төсөлд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагуудыг багасгах асуудлуудыг тусган зохицуулсан.

**5.2.Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилт:**

**1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:**

**1.1.бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх,чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх**

*Хэрэгжилт:*

Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэхээр заасны дагуу Засгийн газраас 2025 оны төсвийн тодотголоор төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулсан.

Тодруулбал, төрийн албаны бүтцийг цомхон, чадварлаг байлгах, төрийн албаны удирдах, гүйцэтгэх орон тооны бүтцийн зөв харьцааг тогтоох, чиг үүргийн давхардлыг арилгах, тэвчиж болох зардлыг хэмнэх, төрийн үйлчилгээг цахимжуулах замаар төрийн албаны орон тоог бууруулах боломжтой гэж үзсэн тул багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах зохицуулалтыг хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын тоо 2024 онд 226,895 байсан бол 2025 онд 213,611 болж нийт 13,284-өөр буурсан.

Яам, агентлагийн тухайд авч үзвэл Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 16 яамдын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Яамдын 142 газар, 147 хэлтэс, албаны тоог цөөрүүлж 114 газар, 95 хэлтэс, албатай болгосноор газрын даргын орон тоо 28-аар буюу 19.7 хувиар, хэлтсийн даргын орон тоо 53-аар буюу 36.5 хувиар тус тус буурсан. Орон тооны дээд хязгаар 1980 байсныг 1812 болгож 168-аар буюу 8.5 хувиар бууруулсан.

Мөн Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолоор 35 агентлагийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталж, 148 газар, 173 хэлтэс, албатай байсныг цөөрүүлж 118 газар, 149 хэлтэстэй болгосон. Ингэснээр газрын даргын орон тоо 30-аар буюу 20.0 хувиар, хэлтэс, албаны даргын орон тоо 24-өөр буюу 14 хувиар тус тус буурсан. Орон тооны дээд хязгаар 3353 байсныг 3061 болгож 292-оор буюу 8.7 хувиар бууруулсан. Мөн Засгийн газрын агентлагийн харьяа аймаг, нийслэл дэх байгууллага, бүтцийн нэгжийн тоо 906 байсныг 75-аар бууруулж 831 болгож, нийт орон тоо 14,300 байсныг 1161-ээр бууруулж 13,139 болгосон.

Төрийн албан хаагчдын орон тоог бууруулсантай холбоотойгоор 2025 онд цалин хөлсний зардлаас 261.0 тэрбум төгрөг хэмнэсэн.

**1.2.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтэд үнэлгээ хийж, тусгай сан тус бүрийн зориулалт, төсөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийлгэж аудитын тайланг, уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх**

*Хэрэгжилт:*

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт тусгай санг татан буулгах үндэслэл бий болсон эсэхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан үзэж, дүгнэлт гаргахаар заасан. Сангийн яамнаас Засгийн газрын тусгай сангуудын хөрөнгийн зарцуулалтыг оновчтой болгох, болзошгүй эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааны ил тод, шударга байдлыг хангах, хугацаа хэтэрсэн өр, авлагыг бууруулах ажлын хүрээнд зээл, татаас, урамшуулал олгодог зарим тусгай сангуудад өмнөх онуудад хийсэн санхүүгийн шалгалтын болон аудитын дүн мэдээ, бүх тусгай сангуудын өмнөх онуудын төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад хийсэн судалгаанд үндэслэн сангуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, зарцуулалтыг оновчтой, үр ашигтай, ил тод болгох, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор дүгнэлтийг боловсруулан ажиллаж байна.

**1.3.гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар**

**санал боловсруулан 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах**

*Хэрэгжилт:*

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд холбогдох судалгаа, тооцоолол хийж, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлж, цахим шинэчлэлийг хийж, хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилтийг Улсын Их Хурлын Ажлын хэсэгт нийт 3 удаа танилцуулсан.

Түүнчлэн, "Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн үр ашиг, бүтээмжийг сайжруулах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслийн нэгжүүдийн чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төслийн нэгжүүдийг нийлүүлэн, нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж болгон өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд нийт 46 тусгайлсан төсөл хэрэгжүүлэх нэгжид 474 орон тоо батлагдсан байсныг салбар бүрд 17 Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид нэгтгэн, орон тоог 204 болгон бууруулсан. Тусгайлсан төсөл хэрэгжүүлэх нэгжийг Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлснээр 2026 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр нийт урсгал зардал 8.65 тэрбум төгрөг буюу 44.4 хувиар буурсан байна.

**1.4.шинээр авах гадаад зээлийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүсчилсэн хөгжлийн бодлого, томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтад чиглүүлж, цаашид хувийн хэвшил хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх**

*Хэрэгжилт:*

Засгийн газар 2025 онд нийт 871.9 сая ам.долларын санхүүжилттэй газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэмэлт санхүүжилт, Эрчим хүч-3 буюу Багануур-Чойр чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барих төсөл, Хотын тээврийг сайжруулах замаар түгжрэлийг бууруулах төсөл, Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл болон Монгол Улсад гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл гэсэн 5 төслийн зээлийн гэрээг байгуулсан. Эдгээр төслүүд нь нийгмийн болон инженерийн дэд бүтцийн төслүүд бөгөөд хувийн хэвшлийн байгууллагуудаас хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэн Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Засгийн газрын гадаад зээлийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан.

Энэхүү зээлийн хэлэлцээрүүд нь Олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурал соёрхон баталснаар хүчин төгөлдөр болох тул хэлэлцээр тус бүрийг соёрхон батлах хуулийг батлуулж ажилласан байна.

Түүнчлэн, Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд шинээр байгуулсан гадаад зээлийн гэрээнүүдийн мэдээллийг Үндэсний аудитын газарт хүргүүлж, 2025 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланд тусгасан бөгөөд шинээр авсан гадаад зээлийн гэрээнүүдэд зөрчил илрээгүй.

**1.5.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах**

*Хэрэгжилт:*

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр, авлага, зээлийн шинжилгээгээр зарим байгууллагын төлбөрийн чадвар сул, авлагын эргэлт удаан, өрийн ачаалал өндөр байгаа нь төсвөөс нэмэлт санхүүжилт, баталгаа болон бусад хэлбэрийн дэмжлэг шаардах эрсдэлтэй байна. Иймд Засгийн газар стратегийн болон нийтийн үйлчилгээний чиг үүргийг төрд хадгалахын зэрэгцээ арилжааны үйл ажиллагааг өрсөлдөөнт зарчимд шилжүүлэх, шаардлага хангасан хуулийн этгээдийн хувьцааг хөрөнгийн биржээр олон нийтэд санал болгох, төр зайлшгүй эрхлэх шаардлагагүй үйл ажиллагааг хувьчлах, чиг үүрэг давхардсан болон үр ашиггүй хуулийн этгээдийг нэгтгэх, өөрчлөн байгуулах, татан буулгах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж ажиллаж байна.

Түүнчлэн хуулийн этгээдийн засаглал, хөрөнгийн удирдлагыг олон улсын жишигт нийцүүлж, төрийн эзэмшлийн хувьцааны тодорхой хэсгийг мэргэжлийн хөрөнгийн удирдлагын тогтолцоонд төвлөрүүлэх замаар ашигт ажиллагаа, хөрөнгийн өгөөж, өр төлбөр барагдуулах чадварыг сайжруулахыг зорьж байна. Мөн үндсэн үйл ажиллагаатай холбоогүй, үр ашиг багатай хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг хязгаарласнаар мөнгөн урсгалын сахилгыг бэхжүүлж, өр, авлагын хуримтлалыг бууруулахын зэрэгцээ төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх эрсдэл, татвар болон ногдол ашгийн боломжит орлогын алдагдлыг бууруулна.

**1.6.аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудал тус бүрийн хариуцлагын асуудлыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нарийвчлан зохицуулах, холбогдох хууль хоорондын уялдааг хангах, хийдэл зөрчлийг арилгах хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх**

*Хэрэгжилт:*

Аудитын дүгнэлтэд дурдсан нийтлэг болон олон давтагдаж байгаа алдаа, зөрчлийн бодит шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор төрийн аудитын байгууллагаас 2025 онд гүйцэтгэсэн аудитын шийдвэрт үндэслэн холбогдох дүн шинжилгээг төсвийн ерөнхийлөн болон төсвийн шууд захирагч тус бүрээр хийж ажилласан. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, төсвийн сахилга бат, хариуцлагыг бэхжүүлэх чиглэл болон хамтран ажиллах албан бичгийг төсвийн бүх ерөнхийлөн захирагч нарт хүргүүлэн ажиллаж байгаа болно.

Түүнчлэн, Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах, уг дүгнэлтийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцүүлж, батлуулахтай холбоотой хугацааны цаглаварт дүн шинжилгээ хийж, бодит нөхцөл байдалтай уялдуулан боловсронгуй болгох зорилгоор “Хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар Үндэсний аудитын газар болон Сангийн яамны холбогдох албан хаагчдын бүрэлдэхүүнтэй хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж

байна. Тус ажлын хэсэг тайлангийн хугацааны цаглаварт дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон хуулийн өөрчлөлтийн талаарх саналыг бэлтгэн ажиллаж байна.

Мөн Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан өргөн мэдүүлсэн "Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1.3-т "төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын уялдаа холбоог сайжруулах, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн удирдлагыг олон улсын сайн туршлагад нийцүүлэх зорилгоор Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2027 оны 11 дүгээр сард багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" талаар тусгасан бөгөөд хууль, эрх зүйн орчны шинэчлэлийг холбогдох судалгаа, дүн шинжилгээ болон олон улсын сайн туршлагыг харгалзан боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна.

**1.7.Хавдар судлалын үндэсний төвийн ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалтын шаардлага хангасан барилгыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс /лизинг/-ийн нөхцөлөөр өөрийн өмчлөлд бүрэн шилжүүлэн авах**

*Хэрэгжилт:*

"Хавдар судлалын үндэсний төвийн ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалтын шаардлага хангасан барилгыг санхүүгийн түрээс /лизинг/-ийн нөхцөлөөр худалдан авах" ЭМЯ/20250101008 дугаартай тендерийг 2025 оны 02 дугаар сарын 11, 03 дугаар сарын 19, 09 дүгээр сарын 24-ний өдрүүдэд тус тус зарласан боловч оролцогч санал ирүүлээгүй.

**1.8.Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх, үүнд шаардагдах нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсвийн жилд зарцуулах**

*Хэрэгжилт:*

Улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлсэн бөгөөд Иргэний нисэхийн ерөнхий газрын улсын төсөвт баталдаг санхүүжилт /урсгал зардал/-ийн ачааллыг бууруулсан.

**1.9.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай зарим газар, байгууллагуудад түрээсийн байр ашиглуулан үйл ажиллагаа явуулах**

*Хэрэгжилт:*

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа 17 байгууллага 2025 онд өөрийн байргүй түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2026 онд 12 байгууллага түрээсийн байр ашиглахаар төлөвлөж 1,032.6 сая төгрөг төсөвт тусгасан.

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
# ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлд:

"24.9.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дагалдан гарсан Улсын Их Хурлын тогтоолуудын хэрэгжилтийг хангах талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан "Засгийн газарт чиглэл өгөх тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 52 дугаар тогтоол, "Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 54 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр доор дурдсан арга хэмжээг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүн, албан тушаалтанд даалгав:

1."Засгийн газарт чиглэл өгөх тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 52 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд:

| № | Арга хэмжээ | Гүйцэтгэх ажил | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|
| 1 | **Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:** | | | |
| 1.1 | ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, бүртгэх, шилжүүлэх, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим санг бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага, татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох | Ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим санг бүрдүүлэх | 2025 он | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Сангийн сайд |
| 1.2 | нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | Хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | 4 дүгээр сар | Сангийн сайд |
| 1.3 | улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт | Холбогдох саналаа Улсын Их Хуралд танилцуулах | 3 дугаар сар | Сангийн сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | магадлал хийх, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах | | | сайд |
| 2 | **Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:** | | | |
| 2.1 | төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран тэдгээрийн засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах | Үр дүнг Улсын Их Хуралд тайлагнах | 2025 он | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 2.2 | төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах асуудлыг судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах | Дүн шинжилгээ хийж, хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах | 2025 он | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 2.3 | төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах асуудлын талаар холбогдох санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | Санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | 2025 он | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 2.4 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох | Хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох | 2025 он | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга |
| 2.5 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх | Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | 1 дүгээр сар | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 2.6 | Төрийн банк болон санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүргээр шинэчлэн зохион байгуулж, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний | Ногоон хөгжлийг дэмжсэн зохион байгуулалт хийж, бүтээгдэхүүний төрөл, хүртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэх | 2025 он | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэмнэлттэй төсөл, хөтөлбөр, хэрэглээг урамшуулан дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэх | | | |
| 3 | **Төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх:** | | | |
| 3.1 | "бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж" гэсэн тухайн төрийн байгууллагын өөрсдөө хийх боломжгүй, тусгай мэргэшил, ур чадвар шаардагдах, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ тухайн ажлын төрөл, цар хүрээ, мэргэжлийн ур чадвар, зах зээлийн үнэлгээнд үндэслэн Засгийн газрын санхүүгийн статистик гаргах аргачлал, загварт нийцүүлж, зардлын эдийн засгийн зүйл болон зориулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ангиллаар нарийвчлан тодорхойлох, цаашид жилийн төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралтад нэмэлтээр тусгах | Жилийн төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралтад нэмэлтээр тусгах | 8 дугаар сар | Сангийн сайд, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар |
| 3.2 | төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн ерөнхийлөн захирагчид "бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж" болон "бусад зардал" гэсэн зардлын ангиллаар төсөв зарцуулах болсон зайлшгүй шаардлага, гарах үр дүн, үр ашгийг тооцож байх | Төсөв зарцуулах шалтгаан, үр дүнг тодорхой болгох | 8 дугаар сар | Сангийн сайд, Бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар |
| 3.3 | олон улсын сайн туршлагад үндэслэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд хуулиар хязгаарлалт тогтоох, уг зардалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах, аудитын тайлангаар баталгаажуулах, олон нийтэд нээлттэй мэдээлэх асуудлын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | 4 дүгээр сар | Сангийн сайд |
| 4 | **Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын программ хангамж, тоног төхөөрөмжийн худалдан авалт, ашиглалтыг сайжруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, салбар хоорондын цахимжилтыг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:** | | | |
| 4.1 | төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдал болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдалд аудит хийж тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд | 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах | 3 дугаар сар | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | танилцуулах | | | |
| 5 | Нийслэл Улаанбаатар хотоос шилжин байрших боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжид байрлуулах, нийслэлд чөлөөлөгдөх барилга байгууламжийн тоо байршил, зориулалтыг судлан жагсаалт гаргаж, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын эээлжит чуулганы хугацаанд холбогдох Байнгын хороонд танилцуулж, шийдвэр гарсны дараа тэднийг худалдах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах | Улсын Их Хурлын 2025 оны хаврын эээлжит чуулганы хугацаанд холбогдох Байнгын хороодод танилцуулж, шийдвэрлүүлэх | 4 дүгээр сар | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 6 | Төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудыг нэгтгэн судалж, 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах | 2025 оны нэгдүгээр улиралд Улсын Их Хуралд танилцуулах | 3 дугаар сар | Сангийн сайд |
| 7 | Төсвөөс олгож байгаа бүх төрлийн татаас, урамшууллын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөлд судалгаа, шинжилгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, төсвийн ачааллыг бууруулах зорилтуудыг уялдуулах санал боловсруулж, 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах | Санал боловсруулж, 2025 оны хоёрдугаар улиралд Улсын Их Хуралд танилцуулах | 4 дүгээр сар | Сангийн сайд |
| 8 | Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төвүүдийг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх | Яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төвүүдийг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх | 2025 он | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд |
| 9 | Цэвэр эрчим хүч үйлдвэрлэх, хогноос сэргээгдэх эрчим хүч гаргаж авах асуудлыг зохицуулах, ногоон эрчим хүч, эдийн засгийг дэмжих хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын эээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх | Хууль тогтоомжийн төслийг 2025 оны хаврын эээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | 4 дүгээр сар | Монгол Улсын Шадар сайд (Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн), Эрчим хүчний сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлийн сайд |
| 10 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын эээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх | Хууль тогтоомжийн төслийг 2025 оны хаврын эээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | 4 дүгээр сар | Сангийн сайд, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд |

2.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд:

| № | Арга хэмжээ | Гүйцэтгэх ажил | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|
| 1 | **Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:** | | | |
| 1.1 | бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх | Ажлын үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх арга хэмжээг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх | 2025 он | Сангийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар |
| 1.2 | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтэд үнэлгээ хийж, тусгай сан тус бүрийн зориулалт, төсөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийлгэж аудитын тайланг, уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх | Аудитын тайланг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх | 4 дүгээр сар | Сангийн сайд |
| 1.3 | гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулан 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах | Санал боловсруулан 2025 оны хоёрдугаар улиралд Улсын Их Хуралд танилцуулах | 4 дүгээр сар | Сангийн сайд |
| 1.4 | шинээр авах гадаад зээлийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүсчилсэн хөгжлийн бодлого, томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтад чиглүүлж, цаашид хувийн хэвшил хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх | Хувийн хэвшил хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх | 2025 он | Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд |
| 1.5 | төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах | Тайланг 2025 оны нэгдүгээр улиралд Улсын Их Хуралд танилцуулах | 3 дугаар сар | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд |
| 1.6 | аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудал тус бүрийн хариуцлагын асуудлыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нарийвчлан | Хуулийн төслийг Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх | 4 дүгээр сар | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зохицуулах, холбогдох хууль хоорондын уялдааг хангах, хийдэл зөрчлийг арилгах хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх | | | сайд |
| 1.7 | Хавдар судлалын үндэсний төвийн ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалтын шаардлага хангасан барилгыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс /лизинг/-ийн нөхцөлөөр өөрийн өмчлөлд бүрэн шилжүүлэн авах | Эмнэлгийн шаардлага хангасан барилгыг өмчлөлд шилжүүлэн авах | 2025 он | Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд |
| 1.8 | Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх, үүнд шаардагдах нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсвийн жилд зарцуулах | Навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсвийн жилд зарцуулах | 2025 он | Зам, тээврийн сайд; Сангийн сайд |
| 1.9 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын салбарын харьяа шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай зарим газар, байгууллагуудад түрээсийн байр ашиглуулан үйл ажиллагаа явуулах | Шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай газар, байгууллагуудад түрээсийн байр ашиглуулан үйл ажиллагаа явуулах | 2025 он | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд, Сангийн сайд |

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР